

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг
нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын
хэрэгжилт, үр дүн**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээ хийгдээгүйгээс зарим боломж, бололцоог орхигдуулсан, нэгдсэн бүртгэл мэдээлэл дутмаг, хэрэгцээ шаардлага хангаагүй системийг ашиглаж байна

АУДИТЫН КОД: БУА-2022/20-4/ШТА-ГА

БУЛГАН АЙМАГ
2022 ОН

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОЭХ	Ажил олгогч эздийн холбоо
БУА	Булган аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХ	Статистикийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын их хурал
УОК	Улсын онцгой комисс
ХААМСҮТ	Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ХБИХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭЗ	Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ШТА	Шууд тайлагнах арга
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2016-2021 оны аймгийн хэмжээн дэх хөдөлмөр эрхлэлтийн түвшин	7
Хүснэгт 2	Булган аймгийн 2016-2021 оны хүн амын тоо, хөдөлмөрийн насны иргэний тоон үзүүлэлт	7
Хүснэгт 3	2016-2021 оны ажилгүй иргэдийн тоо	7
Хүснэгт 4	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт	10
Хүснэгт 5	Аймгийн малжуулах хөтөлбөр	13
Хүснэгт 6	Салбар зөвлөлийн хурал, урамшуулал	14
Хүснэгт 7	Хөдөлмөр эрхлэгчдийн 2017-2021 оны статистик мэдээ	14
Хүснэгт 8	Албан бус хөдөлмөр эрхлэгч	15
Хүснэгт 9	Ажилд зуучлагдсан иргэд /2016-2021 он/	16
Хүснэгт 10	Ажлын байрны ангилал /2016-2021 он/	16
Хүснэгт 11	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016-2021 оны статистик үзүүлэлт	16
Хүснэгт 12	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зарцуулалт	18
Хүснэгт 13	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар албадан гаргуулахаар шилжүүлсэн хөтөлбөрийн жагсаалт	21

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2016-2021 онд Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоон үзүүлэлт	8
График 2	Хөдөлмөр эрхлэгчид /2017-2021 он/	15
График 3	Албан бус хөдөлмөр эрхлэгч	15
График 4	Ажлын байрны захиалга	15
График 5	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016-2021 оны статистик үзүүлэлт	16
График 6	Нийт зуучлалд хамрагдсан иргэн	16
График 7	2016-2021 оны төсөл, хөтөлбөрийн санхүүжилт төлөвлөгөө гүйцэтгэл	19
График 8	Хугацаа хэтэрсэн зээлийн мэдээлэл	21
График 9	ХААМСҮТ-д суралцагчдын тоон мэдээлэл	22

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймгийн малжуулах хөтөлбөр	26-27

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.
Аудитын зорилго	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх - Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байнга эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймгийн Засаг дарга, 16 сум 1 тосгон, аймгийн НБХ, МСҮТ, ХААМСҮТ, ХЭЗ, ХБИХ, СХ, АОЭХ хөдөлмөр эрхлэлттэй холбоотой Төрийн захиргааны төв байгууллага болон ТББ-ын 2016-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн Аудитын Стандарт MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын гүйцэтгэлийн аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглалаа. Аудитыг АДБОС 100, 300, 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглаж зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, судлаач, шинжээч нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллагын санхүүжүүлэх төсөл арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт,

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, аудитор А.Сувдаа, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс аудитыг нээж эхлүүлэн, 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Үндэсний аудитын газрын Гуравдугаар газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

**Хүндрэл
бэрхшээл:**

Аудит хийх ажлын хоног боломжийн боловч санхүүгийн аудит болон судалгааны ажилтай байсан тул зарим үед ажлын ачаалал их байсан болно.

Үндсэн мэдээлэл:

Хөдөлмөр эрхлэлт нь хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийн гол үндэс болохын хувьд УИХ, ЗГ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүй баримт бичгийн хүрээнд ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөр төсөл, ЗГ-аас баталсан төслийг хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.

ХХҮГ-ийн судалгаа, мэдээллээр аймгийн хэмжээнд 2016-2021 онд нийт ХЭДС-гаас нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд зориулж нийт 4594.9 сая төгрөгийг төлөвлөж баталснаас гүйцэтгэлээр 48 төсөл хөтөлбөр, нийтлэг үйлчилгээнд 4070.9 сая төгрөгийг зарцуулж 16009 хүнийг байнгын болон улирал, түр ажлын байр, аймгийн хэмжээнд шинээр бий болсон ажлын байранд нийт 6527 иргэний шинэ ажлын байр бий болсон байна.

Статистик үзүүлэлтээр Булган аймаг 61682 хүн амтайгаас 31475 буюу 50.7 хувь нь эрэгтэй, 49.3 нь эмэгтэй байна. Үүнээс хөдөлмөрийн насны 21871 хүний 49,7 хувь нь эмэгтэйчүүд, ажилгүй иргэдийн 57.8 хувь буюу 1479 нь эмэгтэйчүүд байгаа нь нийт ажилгүйчүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна. 2018 оноос хойш хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин буурсан үзүүлэлттэй байна



БҮЛЭГ 1	Үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг баримталсан ч төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.
----------------	---

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхдээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.1 дэх “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах” гэсэн заалтыг мөрдсөн боловч УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын урт хугацааны бодлоготой уялдаагүй байна.

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2002 оны 92 дугаар тогтоолоор батлагдсанаар Монгол Улс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан бодлоготой болсон.

1.2 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэрэг урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.1 дэх “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах” гэж заасны дагуу Булган аймгийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн талаар богино болон дунд хугацааны төлөвлөгөө гаргасан боловч урт хугацааны бодлогыг төлөвлөж хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.4 Хөдөлмөр эрхлэлтэй холбоотой дунд болон урт хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж тухайн салбарт тулгамдаж байгаа асуудал нь хөдөлмөр эрхлэлт юм. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-тай уялдсан эсэхийг тодотгон харвал аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 58 дугаар тогтоол, 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр буюу мөрийн хөтөлбөр, “Монгол мал” хөтөлбөрийн 2 дугаар үе шат зэрэг богино болон дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр гарган ажиллажээ. Энэ хөтөлбөрүүдэд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр дунд хугацааны бодлогоор 2016-2021 онуудад 5000-6000 иргэнийг ажилтай орлоготой болгохоор төлөвлөж ажилласан боловч Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын урт хугацааны төлөвлөгөө, бодлоготой уялдуулаагүй боловсруулсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ” заалтын дагуу бодиттой тооцоолол судалгаа гаргаагүй байна.

1.5 Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг бодиттой тооцоолж гаргаагүй орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхээр хүн амын нийгмийн хамгааллын болон иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хөдөлмөрийн харилцааны нийтлэг асуудлаар байгуулсан “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны хэлэлцээр”-ийн гэрээний хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон цалин хөлсний үзлэг шалгалт, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх

зорилгоор “Бүтээмж-чанарыг сайжруулах жил”-ийн аяныг зарлан 32 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2000 гаруй ажилтан, албан хаагчийг мэдлэг мэдээллээр ханган ажиллажээ.

1.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ” гэсэн заалтын дагуу нийт хүн ам, хөдөлмөрийн насны иргэн, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 2016-2021 оноор харууллаа.

2016-2021 оны аймгийн хэмжээн дэх хөдөлмөр эрхлэлтийн түвшин

/Хүснэгт 1/

№	Он	ХЭ түвшин
1	2016 он	68.8 хувь
2	2017 он	71.2 хувь
3	2018 он	73.5 хувь
4	2019 он	71.04 хувь
5	2020 он	71.7 хувь
6	2021 он	62.6 хувь

1.7 Аймгийн хэмжээнд 2016-2021 оны хөдөлмөр эрхлэлтийн судалгааг харьцуулан үзэхэд 2016-2020 онуудад 70 хувьтай байсан бол 2021 онд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 9.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Булган аймгийн 2016-2021 оны хүн амын тоо,
хөдөлмөрийн насны иргэний тоон үзүүлэлт

/хүснэгт 2/

№	Он	Нийт хүн амын тоо	Хөдөлмөрийн насны хүн
1	2016	60603	21871
2	2017	61289	23110
3	2018	62214	23716
4	2019	62089	24404
5	2020	61955	19759
6	2021	61943	20105

1.8 2016-2021 оны нийт хүн амын дундаж 61.7 мянган хүн байгаа бол үүнээс хөдөлмөрийн насны хүн нь 22.2 мянган хүн буюу 3.5 хувьтай байна.

2016-2021 оны ажилгүй иргэдийн тоо

/ хүснэгт 3/

№	Он	Ажилгүй хүний тоо
1	2016 он	2304
2	2017 он	3293
3	2018 он	2177
4	2020 он	1671
5	2021 он	3352

1.9 Өмнөх онуудтай харьцуулбал 2021 онд ажилгүй иргэдийн тоо огцом нэмэгдсэн байна. Энэ нь цар тахалтай холбоотой ажилгүй иргэдийн тоо нэмэгдсэн гэж үзэж байна.

1.10 Хөдөлмөрийн зах зээлийн ажил хайгч, ажилд зуучлах үйлчилгээний LMIS программд бүртгэлтэй иргэдээс ажилд зуучлагдсан иргэдийн тоон үзүүлэлтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10.2 дахь “Хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр иргэн, ажил олгогчийг хангах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах” гэж заасны дагуу ажилд зуучилсан иргэнийг графикаар харуулбал:

/график-1/



1.11 Графикаас үзэхэд сүүлийн 2 жилийг өмнөх онтой хариуцуулбал байнгын ажлын байр буурч, түр ажлын байр, улирлын ажлын байрны эрэлт хэрэгцээ нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралт “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 6 дугаар зүйлийн 6.1¹-д заасны дагуу бүх талуудын оролцоог хангаж ажиллаагүй байна.

1.12 Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож мэдээллийн нэгдсэн сүлжээг өргөжүүлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн нарийн мэргэжлийн мэдлэг ур чадвартай ажилтан бэлтгэх, давтан сургах ажлын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн LMIS программын мэдээллийн баазыг өргөтгөх чиглэлээр мэдээллийн санд төрийн 122 байгууллага, төрийн өмчийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагад ажиллаж буй 1157, хувийн хэвшил болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 1490 ажил олгогч байгууллагын 5357 ажиллагсдын ажлын байрыг мэдээлсэн.

1.13 Орон нутгийн бодлогын баримт бичиг хэрэгжиж эхэлсэн үе шатнаас оролцогч талуудын оролцоог хангах талд нэгдсэн бодлого, төлөвлөлт, уялдаа холбоотой ажиллаж чадаагүй бодлогын хэрэгжилтэд оролцогч төрийн захиргааны төв байгууллагуудын хувьд бодлогыг хэрэгжүүлэх тусгайлсан төлөвлөгөө, хөтөлбөр гаргасан боловч аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээ нь бодлогын хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд Төрийн болон ОНӨААН ажлын байрны мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2²-д заасны дагуу мэдээлэх үүргээ биелүүлэхгүй байгаа нь аймгийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байнгын ажлын байр болон шинэ ажлын байрны мэдээллийг хангалтгүй мэдээлсэн байна.

1.14 Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилтай орлоготой болгох зорилгоор 4 зорилт, 37 арга хэмжээ бүхий “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 58 дугаар тогтоолоор баталж 2017-2021 онд хэрэгжүүлэн ажиллажээ. 2021 онд аймгийн нийт хүн амын 63.5 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаа бөгөөд үүнээс 21861 нь буюу 35.6 хувь нь ажил хөдөлмөр эрхлэгчид

¹ Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нийгмийн түнш, иргэдийн оролцоотойгоор хариуцан зохион байгуулна

² Ажил олгогч нь ажиллах хүч болон ажлын байрны холбогдолтой мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид гарган өгөх, эсхүл түүний бүртгэл, мэдээллийн сүлжээнд бүртгүүлж, мэдээллээ байршуулах, мэдээлэлд оруулж байгаа өөрчлөлтийг тухай бүрд нь хийж байх үүрэгтэй бөгөөд ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн биржид гаргаж өгнө.

байна. Урьд оны мөн үетэй харьцуулахад аймгийн хүн амын ажилгүйдлийн түвшин 2.0 хувиар өссөн нь ковидын нөхцөл байдлын үед аж ахуйн нэгж, байгууллагууд олон сараар үйл ажиллагаагаа эрхлэхгүй зогссонтой холбоотой байна. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийхээр 10.0 сая төгрөгийг төсөвлөн "Бүргэд мэдээлэл судалгааны төв"-тэй гэрээ байгуулан ажиллаж, судалгааны дүнг үндэслэн 2022 оноос хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тусгайлан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг боловсруулахад оролцогч талуудын хоорондын уялдаа хангалтгүй байна.

1.15 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд 2016-2020 оны үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 6000-аас доошгүй ажлын байрыг бий болгох, 2020-2024 онд хэрэгжих "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөөр 314.6 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаж 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг зохион байгуулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс эх үүсвэртэй ажлыг зохион байгуулж 5000-аас доошгүй ажлын байр бий болгохоор мөрийн хөтөлбөрт тусгажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхээр ХЭДС-гийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд нийт 4594.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 4070.9 сая төгрөгийг олгосон байна.

1.16 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ажлын байрыг бий болгох зорилт тавьж ажилласан боловч үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцож тусгаагүй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлснээр нийт 1714 ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 5550 иргэнийг байнгын болон улирлын чанартай ажлын байранд зуучлан ажиллажээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд 2016-2019 онд 2770 ажлын байр бий болгосноос байнгын 775, улирлын чанартай 89, түр 1906 ажлын байрыг бий болгож, аймгийн хэмжээнд нийт 8320 ажлын байр бий болгосон байна.

1.17 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхээр ХЭДС-гийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд нийт 4594.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор ХНХЯ-наас батлагдаж, гүйцэтгэлээр 4070.9 сая төгрөгийг олгосон байна.

1.18 2020-2024 онд хэрэгжих цаглавартай аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөөр 314.6 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаж 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг зохион байгуулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс эх үүсвэртэй ажлыг зохион байгуулахаар мөрийн хөтөлбөрт тусгажээ. 2020-2024 оны "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн 2021 онд ажил олгогч 287 байгууллагаас давхардсан тоогоор 1179 ажлын байрны захиалга авч, 808 иргэнийг ажлын байранд зуучлан ажилласнаас байнгын ажлын байранд 410 иргэн, улирлын ажлын байранд 126 иргэн, түр ажлын байранд 272 иргэнийг тус тус зуучилж 2020-2021 онд ХЭДС-гийн хөтөлбөрт 1283.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлуулснаас 1104.3 сая төгрөгийг 4128 иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажлын байртай болгожээ.

1.19 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллуулж буй Баяннуур сумын "Хушт-Эрэг" ХХК-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 4.2.1-д "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгайлсан ажлын байраар хангасан тохиолдолд ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно" гэж заасны дагуу ажил олгогчийн урамшуулал 2.3 сая төгрөгийн олгосон байна. 2017 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан Сайхан сумын "Аргун номт" ХХК, Могод сумын "Эрхт түшиг" ХХК-тай, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд 6-аас дээш сараар ажил идэвхтэй хайж буй иргэнийг ажлын байраар хангасан "Өрнөх учралт" ХХК-тай тус тус ажил олгогчид олгох урамшууллын гэрээ байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөөр 314.6 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ" гэсэн заалтын дагуу шаардагдах санхүүжилтийг тусгуулж байна.

1.20 Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хууль, эрх зүйн орчин үйлчилж байгааг 2019 оны 159 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр", 2019 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

/хүснэгт 4/

Төлөвлөгөө	2016 онд	Гүйцэтгэл
757.6 сая		632.3 сая
↓		
Төлөвлөгөө	2017 онд	Гүйцэтгэл
679.1 сая		586.0 сая
↓		
Төлөвлөгөө	2018 онд	Гүйцэтгэл
697.4 сая		653.2 сая
↓		
Төлөвлөгөө	2019 онд	Гүйцэтгэл
1017.4 сая		901.9 сая
↓		
Төлөвлөгөө	2020 онд	Гүйцэтгэл
685.6 сая		529.6 сая
↓		
Төлөвлөгөө	2021 онд	Гүйцэтгэл
598.3 сая		574.7 сая

1.21 ХХҮГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллээр 2016-2021 онд ХЭДС-гаас хөтөлбөрт, арга хэмжээнд зориулж нийт 4594.9 сая төгрөгийг төлөвлөж баталснаас гүйцэтгэлээр 48 төсөл хөтөлбөр болон арга хэмжээ, үйлчилгээнд 4070.9 сая төгрөгийг зарцуулж 16009 хүнийг байнгын болон улирал, түр ажлын байр, аймгийн хэмжээнд шинээр бий болсон ажлын байранд нийт 6527 иргэний шинэ ажлын байр бий болсон байна.

1.22 Монгол Улсын тариалангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-ын 2016 оны 2/05 тоот тогтоолоор батлагдсан "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн 2.2.5 дахь заалтыг тус тус үндэслэж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар "Булган жимс, жимсгэнэ" хөтөлбөрийг "Хөдөлмөр эрхлэлийг дэмжих аймгийн хөтөлбөр"-т баталжээ.

1.23 Энэ хөтөлбөр нь аймаг, орон нутгийн иргэдийн “Өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод, иргэд жимс, жимсгэний аж ахуй эрхлэх замаар ажлын байр бий болгож, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, улмаар цөлжилтийг сааруулах, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах” зорилготойгоор батлагдаж чацаргана төслийн хүрээнд Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлж 2017 онд чацарганы суулгац нийлүүлэх нийлүүлэгчээр 1, 2-р багцад УБ хотын “Хаан жимс эс би ти” ХХК-тай 183.1 сая, 3, 4-р багцад Өвөрхангай аймгийн “Хархорин” ХХК-тай 193.7 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулан, гэрээний нөхцөлийн дагуу чацарганыг нийлүүлж ажилласан байна.

1.24 Чацарганы суулгацыг 16 сум, 1 тосгоны хэмжээнд түүвэрлэн 9 сумын ургацыг үзэхэд Сэлэнгэ, Булган, Хангал, Тэшиг, Баян-Агт, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны 2021 оны байдлаар 10-40 хувь ургасан байхад Бугат, Орхон сумдын чацарганы ургалт 10 хүрэхгүй хувь буюу маш бага ургасан байна.



1.25 “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 2017 онд Байгаль хамгаалах сангаас 493.9 сая төгрөгийн чацарганы 252306 ширхэг суулгацыг 373 иргэнд олгосон боловч суулгацыг оройтуулж тарьсан, 2017-2018 онд ган болсон мөн чацарганы хашаа муу байснаас шалтгаалж ургаагүй, үр дүн муу байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн хэмжээнд цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийг залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр “Start up” арга хэмжээнд 1 бүлийг 10.0 сая төгрөг, Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн 2 төслийг сонгон шалгаруулж 100.0 сая төгрөгөөр дэмжсэн байна.

1.26 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн гарааны бизнесийг дэмжих “Star up” арга хэмжээний хүрээнд 2021 онд 6 бүлгийн төсөл арга хэмжээг дэмжихээр төлөвлөсөн боловч ковидын нөхцөл байдлын улмаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1 бүлгийг дэмжих санхүүжилтийг олгосон байна. 2021 онд тус арга хэмжээг “Start up Монгол” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж, нийт 15 багийн 42 оролцогчийн бизнес санааг танилцуулан 5 багийг хурдасгуур арга хэмжээнд хамруулан 54 цагийн зөвлөгөө мэдээллийг өгч ажиллажээ. Үүнээс сонгон шалгаруулалтаар Баяннуур сумын залуучуудын бүлгийн “Содон спиннинг” төсөл шалгарч эргэн төлөхгүй нөхцөлөөр 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулж байгаа залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төсөлд 151 иргэн хамрагдсанаас 41 иргэн сургалтад хамрагдаж, 18 иргэн байнгын ажлын байранд зуучлагдан ажиллаж үүний үр дүнд нийт 21 залуу мэргэжилтэй, байнгын ажлын байраар хангагдсан байна.

1.27 Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн төсөл хөтөлбөрт 100.0 сая төгрөгийг ХНХЯ-наас 2018 онд санхүүжилтийг баталснаар орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болгох зорилгоор төслийг зарлаж үүний дагуу нийт 26 ААН төсөл ирснээс сонгон шалгаруулалтыг аймагтаа зохион байгуулж Булган сумын “Их шүүдэргэнэ”, Сэлэнгэ сумын “Бог будаа” гэсэн 2 төслийг тус бүр 50.0 сая төгрөгөөр дэмжиж ажилласнаар байнгын ажлын байр 5, улирлын чанартай ажлын байр 12 бий болгосон байна.

1.28 ХЭДС-гийн төсвийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 1.5 сая, Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын дагуу 0.35 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хоол унааны 4.1 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх урамшуулал 5.1 сая, Жижиг зээлийн хүүгийн хөнгөлөлт 0.7 сая төгрөгийн тус тус зарцуулалгүй буцаан төвлөрүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ч “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болох ажлын байрыг тусгаагүй байна.

1.29 Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Хөгжлийн хөтөч”, “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу төрийн байгууллагуудын тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой хэмжээгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийг тусгаж өгсөн байна.

1.30 Үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт буюу түүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаас үзэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь ХХҮГ-ын ХЭДС-ийн төлөвлөгөөнд тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны дүнгээр илэрхийлэгджээ. Аймгийн үйл ажиллагааны хөтөлбөрт сум орон нутагт хэрэгжиж буй СХС-гийн ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4.3.6³-д, ОНХС-гийн Сангийн сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан журмын 4.2.8⁴, 4.4.8⁵-д болон бусад жижиг зээлийг тусгаж өгсөн ч тус зээл хөтөлбөрийн хүрээнд түр болон байнгын ажлын байр хэрхэн нэмэгдсэн талаар тодорхой тусгаагаагүй нь нэгдсэн бүртгэл, тоо мэдээлэл байхгүй хэрэгжүүлэх журам арга, аргачлал нь харилцан адилгүй байгаагаас шалтгаалжээ.

1.31 Аймгийн ИТХ-ын 2019 оны XI/03 тогтоолоор “Шинэ Хөдөө- Булган” дэд хөтөлбөрийг баталж хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлтэд үйлдвэр, цехийн тоо ажлын байр нэмэгдүүлэхээр тусгасан ч биелэлтийг тооцоогүй, үйл ажиллагааны тайланд ороогүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс, орон нутгийн онцлогт нийцүүлсэн төслийг хэрэгжүүлсэн ч хяналт тавьж ажиллаагүй байна.

1.32 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар тогтоолоор “Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх тухай” баталсны дагуу орон нутагт 2018 онд 100.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 20-ны хурлын тэмдэглэлээр 24 төсөл ирүүлснээс “Бог будаа”, “Их шүүдэргэний өгөөж” төслүүдийг шалгаруулж тус бүр 50.0 сая төгрөгийг 36 сарын хугацаатай буюу 2021 оны 10 сард гэрээ дуусах нөхцөлөөр олгосон, төслийн эргэн төлөлт 2021 оны эцэст 89.9 хувийн биелэлттэй байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/204 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн 3.6⁶-д заасны дагуу сонгон шалгаруулалтыг явуулаагүй, ХЭҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 3.4⁷, 3.5⁸, 3.7⁹-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

³ ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх

⁴ Ажлын байр бий болгох

⁵ Ажлын байр бий болгох

⁶ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон зохион байгуулах аймгуудын хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан ирүүлсэн төслүүдийг хүлээн авч, зохих хууль тогтоомжийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд сонгон шалгаруулах ажлыг жигд нэг удаа зохион байгуулна.

⁷ ХХҮЕГ-т төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулан, аймаг, нийслэл, дүүргээс ирүүлсэн төслүүдийг хүлээн авч, зохих хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын шийдвэрээр баталгаажуулан

⁸ ХХҮЕГ нь батлагдсан төслүүдийг хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, санхүүжүүлэн, хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана

1.33 Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2022 оны 02/429 тоот албан бичгийн хавсралтаар орон нутгийн санхүүжилтээр 2018, 2021 онд аймгийн малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2018 оны хэрэгжилтэд хяналт хийлгэсэн тухай ажлын баримт ирүүлснийг судлан үзэхэд аймгийн Засаг даргын 2017 оны А/323 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдож “Малыг эрсдэлээс хамгаалах сан”-гаас санхүүжүүлэхээр шийдвэр гарсан байна.

1.34 Аймгийн малжуулах хөтөлбөрийн хүрээнд ХХҮГ-тай хамтарч 2018 онд 25 малчинд 125.0 сая төгрөгийн нийт 2605 толгой мал, 2021 онд 17 малчинд 75.0 сая төгрөгийн малыг хүлээлгэн өгсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 01-ээс харах/

Аймгийн малжуулах хөтөлбөр

/Хүснэгт 5/

№	Төсөлд хамрагдсан он	Сумын тоо	Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Худалдан авч өгсөн малын тоо	Үүнд					Хонин толгойд шилжүүлбэл	Дунда ж үнэ
							Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ		
1	2018	13	25	125.00	125.00	2481	1720	771	50	0	0	2659.9	0.047
2	2021	12	17	75.00	75.00	941	473	441	19	8	0	1039.9	0.072
Нийт		25	42	200.00	200.00	3422	2257	1212	69	8	0	3817.8	0.119

1.35 Төслийн хүрээнд ажлын хэсэг орон нутгаас мал худалдан авах гэрээ хийн санхүүжилтийг олгожээ. Худалдан авах гэрээнээс үзэхэд хонин толгойд шилжүүлсэн үнэ 2018 онд 32.6-85.5 мянган төгрөг, 2021 он 49.7-104.2 мянган төгрөгөөр буюу харилцан адилгүй /2.1-2.7 дахин их/ үнээр шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2¹⁰-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, салбар зөвлөлийн хурлын тэмдэглэлд үнэлгээ хийсэн, дүгнэсэн асуудал тусгагдаагүй байна.

Хууль дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй бөгөөд гүйцэтгэлийг хэмжих шалгуур тодорхой бус байна.

1.36 Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2022 оны 02/429 тоот албан бичгийн хавсралт, ХХҮГ-ын баримтаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны хоёрдугаар тогтоолын 2.1.4, 2.2.2, 3.7-д заасны дагуу 2016-2021 онд дараах эрх, үүргийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн санхүүжилтээр аймгийн малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн /өмнөх асуудлын хүрээнд дурдсан/
- ХЭДС-гийн 2016-2021 оны гүйцэтгэлд хяналт тавьсан,
- Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2017 оны А/79, 2021 оны А/201 захирамжаар шинэчлэн баталсан,
- Зөвлөлд 2017-2018 онд нийт 17.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

1.37 Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний салбар зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 2.2.3, 3.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, 2.1.5-2.1.7, 2.2.6, 2.2.8-д заасны дагуу эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Хуралдаанаар хэлэлцэж буй асуудал, түүнтэй холбоотой асууж тодруулсан зүйлс, санал, шүүмж, шийдвэрийг хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгаагүй, тэмдэглэл хүчин төгөлдөр бус,

⁹ Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг 2 жил хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ

¹⁰ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

- Хурлын тэмдэглэлд зөвхөн ХХҮГ-аас хэрэгжүүлсэн ажлын талаар танилцуулга хийгддэг, шийдвэрлэсэн хэсэгт хөтөлбөр, төслийг түргэн шуурхай зохион байгуулах чиглэл өгдөг,
- Өгсөн чиглэлийн хэрэгжилт, биелэлтийг тооцоогүй,
- Орон нутгийн санхүүжилтээр аймгийн малжуулах төслийг хэрэгжүүлэх санал, санаачилгыг гарган үр дүнтэй хэрэгжүүлж байгаа талаар салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга аман тайлбар өгсөн боловч нотлох баримт байхгүй,
- ХЭДС-гийн тайланг хагас болон бүтэн жилээр хэлэлцэж дүгнэсэн, хөтөлбөрүүдийг сумдад хуваарилсан, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг холбогдох байгууллагуудтай хийсэн болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд ХЭДС-гийн үйлчилгээ, арга хэмжээний үр дүнг үнэлсэн тайланг хүргүүлсэн нотлох баримт ирүүлээгүй байгаа тул **албан шаардлага** хүргүүлээ.

1.38 Аудитын хамрах хугацаанд салбар зөвлөлд 17.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна. Тухайлбал сүүлийн гурван жилийн байдлаарх хуралдаан болон урамшууллыг авч үзвэл:

Салбар зөвлөлийн хурал, урамшуулал

/Хүснэгт 6/

/сая.төг/

Он	Салбар зөвлөлийн төлөөлөгчдийн тоо	Хуралдааны тоо	Ирц	Олгосон урамшуулал	Олговол зохих урамшуулал
2019	10	3	22	4.0	2.2
2020	10	2	16	1.9	1.6
2021	10	3	28	3.7	2.8
Нийт	30	8	66	9.7	6.6

1.39 Дээрх хүснэгтээс харахад салбар зөвлөл нь жилд дунджаар 3 удаа хуралдсан нь хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана гэж заасныг хэрэгжүүлж ажилласан харин урамшууллыг оролцоонд үндэслэн хуралдаанд оролцоогүй гишүүнд олгоогүй байна.

1.40 Дээр дурдсан орон нутгийн онцлогт тохирсон төслийг салбар зөвлөл хэлэлцэн шийдвэрлэж ХХҮЕГ-т хүргүүлсэн нь аймгийн салбар зөвлөл эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргаагүй бөгөөд салбар зөвлөлийн гүйцэтгэлд хэрхэн хяналт тавих, үнэлэх эрх зүй орчин тодорхой бус байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

1.41 Засгийн газрын 2016 оны “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаарх баримтлах бодлого”-ын 6.3¹¹-д заасны дагуу орон нутагт бодлогын хэрэгжилтийг тооцохгүй болно.

Булган аймгийн хөдөлмөр эрхлэгчдийг ажил мэргэжлээр сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хөдөлмөр эрхлэгчдийн 2017-2021 оны статистик мэдээ

/Хүснэгт 7/

Ажил мэргэжил	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он IV	Дундаж	хувь
Менежер	790	728	176	597	692	596.6	2%
Мэргэжилтэн	2314	2376	5400	3716	3799	3521	11%
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	166	280	1877	623	753	739.8	2%
Контор, үйлчилгээний ажилтан	540	358	169	376	668	422.2	1%
Худалдаа, үйлчилгээний ажилтан	1718	1881	1037	1056	1195	1377.4	4%
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	17451	17262		13059	15833	15901.2	52%
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	1325	1210	1819	862	629	1169	4%
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	1106	980	1832	1047	1952	1383.4	5%


¹¹Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутам тус тус хийж дүнг Засгийн газарт тайлагнана.

Энгийн ажил мэргэжил	2072	2229	15925	1606		5458	18%
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил					86	86	0%
Нийт	27482	27304	28235	22942	25607	30654.6	100%

Эх сурвалж: 1212.mn

Үүнийг графикаар харуулбал:

/график 2/




1.42 Графикаас үзэхэд аймгийн хэмжээнд 2017-2021 оны статистик тоо мэдээгээр дунджаар авч үзвэл хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан 52, мэргэжилтэн 11, энгийн ажил мэргэжил 18 орчим хувийг эзэлж байна.

/Хүснэгт-8/

Эдийн засгийн салбар	2019 он	2020 он	Өөрчлөлт
ХАА-н салбар орсон	16416	13653	(2763)
ХАА-н бус салбарт	2178	719	(1459)
Нийт	18594	14372	(4222)

АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ



Үүнээс үзэхэд албан бус хөдөлмөр эрхлэгчийн тоо сүүлийн жилд 22.7 хувиар, түүний дотор ХАА бус салбарт ажиллах ажилчдын тоо 33.0 хувиар буурсан байна.

БҮЛЭГ 2 Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд тавих хяналт сулаас үр дүнг тооцоогүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг бодитой тайлагнаж үнэлээгүй байна.

2.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажилд зуучлах үйлчилгээг үзүүлж байна. Үйлчилгээнд 2017-2021 онд нийт 8,037 иргэн хамрагдаж 73,9 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.2 Ковид-19 цар тарах гарсантай холбогдуулж УОК-оос олон нийтийн хөл хориог 2020, 2021 онд тогтоосон ч 2020-2021 онд сумдад ажиллаж, үйлчилгээг цахимаар бус биетээр явуулжээ.

2.3 Аудитын хамрах хугацаанд ХХҮГ-т нийт 9366 ажлын байрны захиалга ирснээс 5595 ажлын байрны захиалга зуучлагдаж, нөхөгдөөгүй нийт 40

Ажлын байрны захиалга



хувь буюу 3771 сул ажлын байр байна. Ажлын байрны захиалгын хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд тус программд автоматаар устгадаг тохируулгатай байна.

Ажилд зуучлагдсан иргэд /2016-2021 он/

/Хүснэгт 9/

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт
Нийт захиалга	983	1633	2333	1762	1191	1464	9366
Зуучлагдсан	525	1081	1200	1011	866	912	5595
Зуучлагдсан хувь	53%	66%	51%	57%	73%	62%	60%
Зуучлагдаагүй	458	552	1133	751	325	552	3771

Эх сурвалж: Imis-программаас 2016-2021 он

2.4 Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2016-2018 онд өсөлттэй, 2019-2021 онд бууралттай бөгөөд 2020 онд хамгийн бага иргэнийг зуучилсан нь ковид-19 цар тахлын үед хөл хорио тогтоож аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа түр зогссоноос шалтгаалсан байна.

2.5 Сүүлийн 5 жилийн тоон мэдээнээс үзэхэд жилд дунджаар 2658 иргэн ажилтай болсон ч хөдөлмөр эрхлэлтийн дундаж түвшин 66.7 хувь, ажилгүйдлийн дундаж түвшин 7.8 хувь байна. Үүнийг хүснэгт болон графикаар харуулбал.

Ажлын байрны ангилал /2016-2021 он/

/Хүснэгт 10/

Ажлын байрны төрөл/ Он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт	Дундаж
Байнгын	1457	1839	1030	540	618	5484	1097
Түр	376	901	1073	1616	1298	5264	1053
Улирлын	821	459	467	256	541	2544	509
Нийт	2654	3199	2570	2412	2457	13292	2658

Эх сурвалж: Imis-программаас 2016-2021 он

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016-2021 оны статистик үзүүлэлт

/Хүснэгт 11/

Статистик үзүүлэлт	Насны бүлэг	2016	2017	2018	2019	2020	2021- IV	Дунда ж
Ажилгүйдлийн түвшин, %	Бүгд	8.2	10.7	7.4	5.7	6.8	0.3	7.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	Бүгд	66.4	67.6	68.9	69	62	62.2	66.8

Эх сурвалж: 1212.mn



2.6 Графикаас харьцуулж үзэхэд ажилд зуучлах арга хэмжээ хөдөлмөр эрхлэлтийн түвшинд шууд, ажилгүйдлийн түвшинд урвуугаар нөлөөлөх ч харгалзах онуудын хувьд харилцан адилгүй байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлж байна:

- Статистик тоо мэдээлэл нь нэгдсэн програмаас нэгтгэгдэн тооцоологдож гардаг бөгөөд тухайн сумдын багийн Засаг дарга нар иргэдийн мэдээллийг үнэн бодит, түргэн шуурхай бүртгэдэггүйгээс,
- ХЭДС-гаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйлчилгээний дүнд байнгын болон түр ажлын байр бий болсон ч ажлын байрны үйл ажиллагаа тогтворжоогүй,
- Тухайн хөтөлбөр, үйлчилгээнд хамрагдсан иргэний эрхлэх ажил, үйлчилгээг байнгын болон түр ажлын байрыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар бүртгэдэг,
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 2017-2021 онд нийт 8,038 иргэн хамрагдсан зэрэг мэдээллээс ажлын байрны тоо мэдээ, статистик үзүүлэлт үнэн зөв, бодиттой илэрхийлэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

Нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем бий болоогүй, ашиглаж байгаа программ хангамж шаардлага хангахгүй, мэдээллийн системийн бодитой бус бүртгэлээс болж арга хэмжээнүүдийн үр дүнг тооцох боломжгүй байна.

2.7 Орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой www.lmis.gov.mn программыг 2014 оноос ашиглаж байгаа бөгөөд тус программ нь зөвхөн ажил хайгч иргэн, ажил олгогч ААН байгууллагын хүсэлтийг үндэслэн сумын мэргэжилтний бүртгэсэн мэдээлэл болон зуучилсан иргэдийн мэдээллээр хязгаарлагдаж байна.

2.8 Холбогдох албан тушаалтнаас нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн талаар тодруулахад байгууллага цахим орчинд ажил хайгч болон ажил олгогч иргэдийг бүртгэх /facebook./ хуудсыг 2019 оноос хөтлөн явуулж байгаа талаар дурдсан бөгөөд бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг цуглуулж www.lmis.gov.mn программд бүртгэж байна.

2.9 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17.1¹², 19.2¹³, 20.4¹⁴, 29.9.7¹⁵-д нэгдсэн бүртгэл мэдээллийн сан, түүний бүрдүүлэлт, судалгаа гаргалт, хадгалалт хамгаалалтыг тусгасан ч ХЭДС-гаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах, хамрагдсан төсөл хөтөлбөрийн нэгдсэн бүртгэл байхгүй байна. Эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн бүртгэлд <http://heds.axplorer.net/> цахим системийг 2020 оны 06 дугаар сараас нэвтрүүлсэн, уг системд одоогоор зээлийн шивэлтийг хийж бүртгэл үүсгэж байгаа ч ашиглалт шаардлага хангахгүй байгаагаас нягтлан бодогч зээлийн мэдээллийг excel программ дээр он тус бүрээр бүртгэл үүсгэн төлөлт хийгдсэн үед зээлийг хааж байна. Цахим системд зээлийн мэдээллийг бүрэн оруулаагүй нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрэх, устах, мэдээллийг өөрчлөх эрсдэл үүсэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцоогүй, салбар зөвлөлөөр дүгнүүлээгүй байна.

2.10 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 8,038 иргэнийг хамруулж 73.9 сая төгрөгийг зарцуулжээ. Сүүлийн таван жилээр гүйцэтгэлийг харуулбал:

¹² Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь ажиллах хүчний талаарх мэдээ, мэдээлэл, ажлын байрны болон ажил хайгч, ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэгч болон уг үйл ажиллагаанд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдсон бүртгэл, мэдээллийг агуулна.

¹³ Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны болон аюулгүй байдал, хамгаалалтын журам, стандартыг тогтоох, хяналт тавих, программ болон техник хангамжийг хөгжүүлэх чиг үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

¹⁴ Иргэн өөрөө интернэтийн орчинд болон хөдөлмөрийн биржид очиж мэдээллийн санд бүртгүүлж, мэдээллээ байршуулах ба хэрэгцээт мэдээллээ олж авч болно

¹⁵ аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зарцуулалт

/Хүснэгт 12/

/сая.төг/

Үзүүлэлт	2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он		Нийт	
Зардлын ангилал	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө
АМЧБО,ЗӨ	65	3.8	1199	8.6	3823	18.5	500	2.7	894	7.2	6481	40.8
Ажилд зуучлах үйлчилгээ	0	6.0	192	9.2	143	9.6	405	3.8	817	4.5	1557	33.1
Нийт	65	9.8	1,391	17.8	3,966	28.2	905	6.5	1,711	11.7	8038	73.9
Нэг хүнд ногдох зардал	0.151		0.013		0.007		0.007		0.007		0.009	

Эх сурвалж: 2017-2021 оны төсөл, хөтөлбөрийн тайлангаа

2.11 Үүнээс үзэхэд нэг хүнд ногдох зардал 0.01-0.15 сая төгрөг буюу сүүлийн гурван жилд хамрагдсан иргэдийн тоо харилцан адилгүй буюу 905-1711 иргэнд 6.5-28.2 сая төгрөгийг зарцуулсан ч нэг хүнд ногдох зардалд өөрчлөлт ороогүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний 2020-2021 оны зарцуулалтад түүвэрлэн үзэхэд ХХҮЕГ-аас ирүүлсэн ном, гарын авлагыг хэвлэлийн газраар олшруулж үйлчилгээнд хамрагдсан иргэдэд олгодог ч нотлох баримт дутуу, сургалт явуулсан багшийн зардлын нотлох баримт дутуу, ковид-19 цар тахлын үед үйлчилгээг цахим бус биетээр явуулж гарын авлага, ном, боршур тараасан байна. Нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгөнд судалгаа, шинжилгээ хийгээгүй, салбар зөвлөл үнэлж, дүгнээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр 2019 онд Швейцарын хөгжлийн агентлагаас залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулсан байна. Мөн Булган хангай МСҮТ, ХААМСҮТ-д ОУ-ын санхүүжилтээр 1358.4 сая төгрөгийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр сургалтын орчноо сайжруулжээ.

2.12 Олон Улсын санхүүжилтээр 2019 онд Швейцарын хөгжлийн агентлагаас залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг ХХҮГ-т байгуулж үүгээрэй хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой МСҮТ төгсөгч залуучууд болон ажил хайгч залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, гарааны бизнесийн төсөл бичих заавар зөвлөгөө зэрэг үйлчилгээг үзүүлдэг байна. Булган хангай МСҮТ-д олон улсын төсөл хөтөлбөрийн шугамаар 578.4 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлсэн бол ХААМСҮТ-д Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн 780.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургалтын орчин сайжруулах зорилгоор малын асаргаа, хүлэмжийн аж ахуйн фермер, хүнсний ногооны фермер, малын эмчийн лаборатори, онолын хичээлийн байрны засвар үйлчилгээ, иж бүрэн багаж тоног төхөөрөмжөөр сургалтын орчноо сайжруулсан байна.

2.13 Манай аймгийн хувьд ЗГ-аас хэрэгжүүлдэг Гадаадад ажиллах хүч илгээх арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг жил бүр ХХҮЕГ, орон нутгийн удирдлага, салбар зөвлөлд тайлагнадаг боловч үнэлээгүй, дүгнэлт өгөөгүй байна.

2.14 Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг жил бүр хэрэгжүүлж “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 16 сум, 1 тосгоныг хамруулж 50-200 хүртэлх толгой малтай 90 өрхөд 405.0 сая төгрөгийн мал худалдан авч өгч 90 өрхийн 180 иргэнийг байнгын ажлын байраар хангажээ.

2.15 “Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах хөтөлбөр”-т 57.6 сая төгрөгийн 45 төсөл ирснээс 10 сумын 43 төслийг 92.0 сая төгрөгөөр дэмжиж нийт 446 иргэнийг түр ажлын байраар хангасан байна.

2.16 Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 890.0 сая төгрөгийн 243 төсөл ирснээс 117 иргэний 55 төсөлд 280.0 сая төгрөгөөр дэмжиж, үүний үр дүнд 64 байнгын ажлын байр бий болжээ.


2.17 Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээ, нийтийг хамарсан ажил зохин байгуулах арга хэмжээнд нийт 215 иргэнийг хамруулан түр ажлын байраар ханган өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна.

2.18 “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-т хөдөлмөрийн харилцааны ур чадвар олгох, нийгэмшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 58 иргэнийг хамруулж мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэн чадамжийн гэрчилгээ олгосноор 36.1 хувь нь буюу 30 иргэн ажлын байртай болжээ.

2.19 “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр” тус хөтөлбөрт 16 ахмадын 52 сая төгрөгийн төсөл ирснээс 10 ахмадын төслийг 10.0 сая төгрөгөөр тус тус дэмжиж 10 байнгын ажлын байртай болсон байна. Үүний үр дүнд зөвлөх үйлчилгээ үзүүлснээр 75 иргэн түр ажлын байртай болжээ.

2.20 Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр” 341.3 сая төгрөгийн 118 төсөл ирснээс 26 төслийг 33.0 сая төгрөгөөр дэмжиж 28 байнгын ажлын байр бий болсон байна. “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-д 12.5 сая төгрөг батлагдаж үүнд 10 иргэнийг хамруулж орлогын эх үүсвэртэй болжээ.

2016-2021 оны төсөл, хөтөлбөрийн санхүүжилт төлөвлөгөө гүйцэтгэл /график 7 /



Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9 дахь “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажил олгогчийн жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй” гэсэн заалтын дагуу эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.21 Булган аймаг 61682 хүн амтайгаас 31475 нь буюу 50,7 хувь нь эрэгтэй, 49,3 нь эмэгтэй байна. Үүнээс хөдөлмөрийн насны 21871 хүний 49,7 хувь нь эмэгтэйчүүд, ажилгүй иргэдийн 57.8 хувь буюу 1479 нь эмэгтэйчүүд байгаа нь нийт ажилгүйчүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

2.22 Аймгийн хэмжээнд нийт 2400 гаруй нэн ядуу буюу харьцангуй бага хэрэглээтэй амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхүүд байдаг. Эдгээр өрхийн

24.0 хувь нь өрх толгойлон амьдарч байгаа эцэг, эхчүүд, өөрөөр хэлбэл өрх толгойлон амьдарч байгаа 1776 иргэний 1390 нь эмэгтэйчүүд, үүний 50 гаруй хувь нь ажилгүй, өрхийн орлого багатай, хөдөөгийн малчин өрхүүд байна.

2.23 2016-2021 онд аймгийн хэмжээнд шинээр бий болсон ажлын байранд нийт 6527 иргэнийг хамруулж ажилтай орлоготой болсон бол үүний 2821 иргэн нь эмэгтэйчүүд шинэ ажлын байраар хангагдсан байна.

2.24 Булган аймгийн хэмжээнд эмэгтэйчүүдийг дэмжих “Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн өглөөний цай уулзалт”, “Эмэгтэйчүүдийн хөгжил-оролцоо” зөвлөгөөн, “Байгууллагын соёл ба эмэгтэйчүүдийн манлайлал” лекц гэх мэт сургалт, зөвлөгөөнд эмэгтэйчүүдийг хамруулж хөгжил талаас нь дэмжиж байгаа ч эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр төлөх үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9.6¹⁶, 29.9.13¹⁷-д заасны дагуу холбогдох байгууллагад албан тоот хүргүүлдэг ч орлого дутуу төвлөрсөн байна.

2.25 ХХҮГ-аас ХЭДС-д төвлөрүүлэх төлбөрийг 25 иргэнээс дээш ажилтантай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагад албан тоот хүргүүлэх, ажил үүргийн дагуу хуулийн талаар сурталчлах ажлыг явуулж, сүүлийн 5 жилийн байдлаар 5,2 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Энэ талаар тодруулахад:

- Аймгийн ихэнх байгууллага нь төрийн байгууллага байдаг, төсөвт тусгагдаагүйгээс төлөх боломжгүй талаар тайлбарладаг,
- Зарим хууль, хүчний байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах боломж байхгүй,
- Ковид-19 цар тахал гарсантай холбоотой хувийн хэвшлийн үйл ажиллагаа сүүлийн хоёр жил зогссон,
- Эрх хэмжээний хүрээнд байгууллагад албан тоот хүргүүлдэг ч албадан гаргуулах эрх зүйн үндэс байхгүйгээс мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэх арга хэмжээг авч ажилласан талаар тайлбар өглөө.

2.26 ЭМДХ-ээс аймгийн хэмжээнд 25-аас дээш ажилтантай нийт 81 байгууллага байгаагаас ХХҮГ-ийн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах боломжтой байгууллагын огт ажиллуулдаггүй 7 байгууллага, дутуу ажиллуулж байгаа 6 төрийн байгууллагаас /39.3 сая төгрөг/ байна. Эдгээр байгууллагууд нь төсөвт байгууллага бөгөөд Засгийн газрын 2009 оны 29, 2019 оны 111 дүгээр тогтоолын дагуу ХБИ-ийг ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх нөхөн төлбөрийг аудитын хамрах хугацаанд дунджаар тооцвол 138.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж байсан байна.

2.27 Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах боломжтой ААН, байгууллын судалгааг бүрэн гаргадаггүй байна.

2.28 ХЭДС-гаас хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн эргэн төлөлтөөр 2017-2021 онд 232.5, 266.4, 298.5, 221.6, 465.5 сая нийт 1,484.5 сая төгрөг төвлөрсөн нь тус онуудад дунджаар олгосон зээлийн дүнгийн 80 орчим хувийг эзэлж байна.

ХЭДС-гийн хөрөнгийг зарцуулахдаа хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.29 ХЭДС-гаас 2017-2021 онд 882.2, 1,094.8, 1,348.5, 793.1, 1,042.6 сая төгрөг нийт 5,161.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулалттай холбоотой дараах алдаа, зөрчил илэрлээ.Үүнд:

¹⁶ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг байгууллага, иргэнд сурталчлах,

¹⁷ энэ хуулийн 22.1.7-д заасан төлбөрийг төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу,
- Эргэн төлөлтийг хуваарьт хугацаанд төлдөггүй,
- Нэгдсэн бүртгэлийн сан үүсгээгүй,
- Эрх үүргийн хүрээнд шийдвэр гаргадаггүй,
- Төсөлд хамрагдсан иргэн зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулдаггүй,
- Төслийг хэрэгжүүлдэггүй,
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг үнэлээгүй,
- Зарцуулалтыг хагас, бүтэн жилээр дүгнээгүй, үр нөлөөг тооцоогүй 3Г-ын 2011 оны 375 дугаар тогтоол 5.1 , хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29.9.7 , 29.9.9, 29.9.13 , ХЭҮЗ-ийн 2017 оны 02 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.30 Эдгээр алдаа, зөрчил гарахад дараах хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

- Эрх хэмжээний хүрээнд байгууллагад албан тоот хүргүүлдэг ч албадан гаргуулах эрх зүйн үндэс байхгүйгээс мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэх арга
- Төсөл, хөтөлбөрийг хэрхэн үнэлэх, дүгнэх арга зүй дутмаг,
- Бүртгэл, мэдээллийн программ шаардлага хангадаггүйгээс гар ажилбар их,
- Программын системд шинэчлэл, сайжруулалт хийддэггүй,
- Зээлийн гэрээнд зээлдэгчийн хүлээх үүргийг тодорхой тусгаагүй, зөвхөн шүүхийн байгууллагаар шийдүүлдэг,
- Хэрэгжилтийн бодит үр дүн, үр нөлөөг тооцдоггүй, судалгаа хийгддэггүй зэргээс хууль, журмын хэрэгжилт бүрэн хангалтгүй байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн мэдээлэл

/график 8 /



Хөтөлбөр, төсөлд хамрагдсан зээлдэгчдийн эргэн төлөлтийг судлан үзэхэд 2021 оны эцэст 82 иргэний 141.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлдэгч байгаагаас ХХҮГ-аас ирүүлсэн ШШГГ-ын шийдвэр гарсан зээлдэгчдийг хасаж 40 иргэний 50.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, аудитын гүйцэтгэх үе шатны ажлаар талбарт ажиллахад Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан Булган сумын 5 иргэний 50.0 сая төгрөгийн төсөл хэрэгжээгүй нийт 100.6 сая төгрөгийн зөрчилд шүүх хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах хугацаатай **албан шаардлага** хүргүүллээ.

2018-2019 онд эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд хуваарийн дагуу хийгдээгүй хөтөлбөр арга хэмжээ

/хүснэгт 13/

/сая.төг/

№	Хөтөлбөр арга хэмжээ	Он	Дэмжигдсэн санхүүжилт	Үлдэгдэл
1	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2018	30.0	24.4

2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2018	26.0	15.1
3	Малжуулах хөтөлбөр	2019	43.0	35.4
4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2019	6.0	4.98

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар албадан гаргуулахаар шилжүүлсэн хөтөлбөрийн жагсаалт

/хүснэгт 14/


№	Сумын нэр	Он	Хамрагдсан хөтөлбөр	Дэмжигдсэн санхүүжилт	Үлдэгдэл
1	Булган сум	2017	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	3.5	3.4
2	Бүрэгхангай сум	2016	Малжуулах хөтөлбөр	2.5	0.9
3	Могод сум	2016	Малжуулах хөтөлбөр	2.5	2.5
4	Хутаг-Өндөр сум	2018	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4.0	3.66
5	Сайхан сум	2018	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2.5	1.8
6	Хишиг-Өндөр сум	2018	Малжуулах хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	7.0	7.0
Нийт дүн				22.0	19.2

2.31 ХЭДС-гийн төсөл хөтөлбөр хамрагдсан 6 сумын 9 иргэний эргэн төлөлт хийгдээгүй байсныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулж өгсөн хугацаанд 19.2 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй тул ШШГА-ны албадан гаргуулах шийдвэрийг гаргуулсан байна.

2.32 МСҮТ-ийн 2.5 болон 1 жилийн ангиудад 30 мэргэжлийн чиглэлээр 1025 оюутан суралцаж төгссөнөөс төгсөгчдийн 59 хувь буюу 604 оюутан ажилтай болсон ба 45 хувь нь мэргэжлээрээ ажиллаж мөн мэргэжил олгох түр болон давтан сургалтаар 15 мэргэжлийн чиглэлээр 268 иргэнд мэргэжил эзэмшүүлж 58 иргэний ажлын байрыг хадгалж 116 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна.

2.33 Булган аймаг дахь ХААМСҮТ-д суралцагчдын тоон мэдээллийг оноор харьцуулан харуулбал:

/график 9/



2.34 Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулж байгууллагуудтай хамтран ажиллажээ. Үүнд:

- Мэргэжил бүх сайхан өдөрлөгийг ХААИС, ХХААГ-тай зохион байгуулж бэлтгэж буй мэргэжлүүдийн талаар иргэдэд танилцуулга хийж, төгсөгч нарын ур чадварын уралдааныг зохион байгуулсан байна.
- ХХҮГ-аас мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж сургалтын байгууллагын үйл ажиллагааы мэргэжлийн ангийн 5 төгсөгч гарааны дэмжлэг 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдаж ажлын байртай болжээ.
- 2016-2017 оны хичээлийн жилд Булган сумын Сум дундын ой анги, БОАЖГ-аас нөхөрлөлийн гишүүдийг чадавхжуулах, ажлын байраар хангах ажлыг зохион байгуулснаар 16 нөхөрлөлийн гишүүнд ойжуулагч мэргэжил эзэмшүүлж, БОАЖГ-аас 12 нөхөрлөлд хүлэмж болон багаж хэрэгсэл олгосон байна.
- Хөдөө аж ахуйн газар нь жимс жимсгэнэ хөтөлбөрт 10 бүлийн гишүүн 10 иргэнийг сургаж өөрсдийн жимсний аж ахуйг хөгжүүлэн ажиллаж байна.
- Бизнес аж ахуй эрхлэх сургалтыг ХХҮГ-аас зохион байгуулж сургуулийн 10 төгсөгч хамрагдаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагджээ.
- Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран Эрэлт-сургалт-ажлын байр хөтөлбөрийг өрхийн аж ахуй эрхлэгч 22 иргэнийг хүлэмжийн аж ахуй фермер мэргэжлээр сургаж суралцагчид хувиараа аж ахуй эрхэлж байна.
- 2018 оноос төгсөгчдийн болон ажил эрхлэлтийн судалгаа мэдээллийг ХХҮГ-т хүргүүлж төгсөгч нарыг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн санд бүртгүүлж ажиллаж байна.
- 2019 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих төсөлд ойжуулагч мэргэжлийн ангийн 5 төгсөгч бүлэгт “хусны нүүрс бэлтгэх төслөөр 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, “Хатан мээж” ХХК-иас төгсөгчдийг ажлын байраар хангах уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж үүний үр дүнд 3 төгсөгч ажлын байртай болжээ.
- Багш болон суралцагч солилцоо, мэргэшүүлэх, туршилт судалгаа хамтран зохион байгуулах ажлыг аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Оиска ОУБ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ш.Насандуламтай хамтарч ажилласнаар 1 багш Япон улсад оргоник тариалангийн чиглэлээр 1 жилийн хугацаанд суралцах гэрээ байгуулсан хэлний бэлтгэлд хамрагдаж 2022 оны 04 дүгээр сарын 21-нд гэрээний дагуу сургалтдаа явахаар төлөвлөгдсөн байна.

2.35 ХНХЯ-ны харьяа сургалтын байгууллагуудын төсвийн үр ашгийг тооцож үзэхэд нэг суралцагчид ногдох зардал тогтмол өссөн байна. Тухайлбал, 2016 онд 1.7 сая төгрөг байсан бол 2020 онд 2.9 сая төгрөг болж 2 дахин өссөн байна.

2.36 МСҮТ-үүдийн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлын хүрээнд ХААМСҮТ "Багшийн хөгжлийн төв"-ийг шинээр байгуулж ашиглалтад оруулсан, Мөн ХНХЯ, Азийн хөгжлийн банкны Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд Хүнсний ногооны фермер, Хүлэмжийн аж ахуйн фермер, Малын асаргаа мэргэжлүүдийн онолын танхим, лабораторийн барилга болон 8х20 харьцаатай өвлийн хүлэмжийг сэргээн засварлаж, 67 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 273.6 сая төгрөгийн санхүүжилтээр авч хичээл сургалт, дадлагын үйл ажиллагаандаа ашиглаж эхэлснээр оюутан сурагчдын сурах орчин нөхцөл бүрэн шинэчлэгдэж, орчин үеийн стандартад нийцсэн техник тоног төхөөрөмжөөр хангагдаад байна. Зөгийн аж ахуй эрхлэгч мэргэжлийн ангийн сургалтын баазыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд малын удмын сангийн үндэсний төвөөс хөнгөлөлттэй нөхцөлөөр 10 бүл зөгий авч дадлагын бааз суурийг нэмэгдүүлжээ. Булган Хангай МСҮТ өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан сургуулийн багш, суралцагч нарын сурах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр засвар тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, үр нөлөөнд нотлох баримт бүрдээгүй тул үнэлэх боломжгүй байна.

2.37 Ковид-19 цар тахал 2020 оноос дэгдэж иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаа, давтамжаар хөл хорио тогтоож нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, сахих арга хэмжээг УОК, ЗГ-аас авч хэрэгжүүлснээс хөдөлмөр эрхлэлт

хязгаарлагдаж, орон нутагт хийгдсэн тооцоо судалгаа, нэгдсэн бүртгэл мэдээлэл буюу зохистой нотлох баримт байхгүйгээс дүгнэлт өгөх боломжгүй байна.

Санал асуулга:

Ажил эрхлээгүй иргэдээс 16 асуудал бүхий санал асуулга явуулахад 65 иргэн хамрагдсан байна. Санал асуулгын үр дүн:

1. Булган аймгийн харьяат 65 иргэн,
2. Нийт санал асуулгад хамрагдсан иргэний 38.5 хувийг 35-45, 33.8 хувийг 26-34 насны иргэд,
3. Эмэгтэй 66.2, эрэгтэй 33.8 хувь
4. Боловсролын түшингээр авч үзэхэд дийлэнх буюу 60 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд,
5. Судалгаанд хамрагдсан иргэдийн 66.2 хувь нь өмнө ямар нэг хөдөлмөр эрхэлж байсан, 33.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагүй иргэн, өмнө хөдөлмөр эрхэлж байсан иргэдийн 36.4 хувь нь төрийн, 25 хувь нь үйлчилгээний салбарт, 15.9 хувь нь ХАА-н салбарт ажиллаж байсан иргэд,
6. Ажилгүй байгаа хугацааны 46.9 хувь нь 3 жилээс дээш, 25 хувь нь 1-3 жил, 21.9 хувь нь 1-6 сар ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд,
7. Судалгаанд хамрагдсан иргэдийн 24.2 хувь нь төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайгчаар, 21 хувь нь ажлын зарын дагуу, 14.5 хувь нь хувийн бизнес эрхлүүлэх, 12.9 хувь нь ямар нэгэн оролдлого хийгээгүй иргэд,
8. Орон нутгийнхаа ажилгүй иргэдийн бүртгэлд 28.6 хувь нь бүртгүүлээгүй иргэд бөгөөд 52 хувь нь бусад, 28 хувь нь хаана бүртгүүлэхээ мэдэхгүй, 20 хувь нь бүртгүүлэх шаардлагагүй гэж үзсэн байна.
9. Судалгаанд хамрагдсан иргэдийн 43.1 хувь нь хүүхдийн мөнгө, 40 хувь нь гэр бүлийн гишүүдийн орлого,
10. Төрөөс хэрэгжүүлж буй үйлчилгээ, хөтөлбөрт 65.6 хувь нь хамрагдаж байгаагүй бол 34.4 хувь нь хамрагдсан, хамрагдсан иргэдийн 60 орчим хувь нь сэтгэл хангалуун, 9 орчим хувь нь сэтгэл хангалуун бус,
11. Үйлчилгээнд хамрагдсанаар 38.2 хувь нь 1-3 сар, 32.4 хувь нь 3-6 сар, 20.6 хувь нь 6-12 сар, 8.8 хувь нь 1 жилээс дээш ажлын байраар хангагдсан,
12. Төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих мэдээллийг 46.9 хувь нь цахим, 20.3 хувь нь бусад, 18.8 хувь нь баг хороо, 12.5 хувь нь таньдаг хүнээс авдаг,
13. Тохирох ажил олдохгүй байгаа 21.9 хувь, бусад болон ар гэрийн байдлаас 20.3 хувь нь ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд,
14. Оршин суугаа газарт ажлын байрны олдцыг 46 хувь нь муу, 44.4 хувь нь дунд, 9.5 хувь нь сайн,
15. Ажил, хөдөлмөр эрхэлсэн боловч өөрт хамааралгүй шалтгааны улмаас цалингаа авч чадаагүй иргэн 12.9 хувь,
16. Ажилд ороход 38.7 хувь нь ажлын туршлага, 27.4 хувь нь боловсрол, 12.9 хувь нь наснаас хамаарч байна гэж үзжээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг томоохон бодлогын баримт бичигт холбогдох хууль журам тэдгээрийн шинэчлэлд шаардлагатай суурь тоон мэдээлэл, зөвлөмжөөр хангах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэр дотор санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх хөрөнгө орж, зарлага нь зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг байнгын болон түр ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлсэн санхүүгийн дэмжлэг авсан иргэдээс төслийн явцын болон санхүүгийн, эргэн төлөлт хангалтгүй, хуваарийн дагуу төлөлт хийгддэггүй зэрэг асуудлууд нь түгээмэл төдийгүй цаашид ч үргэлжлэх магадлалтай байна. Мөн Эргэн төлөлт хийхгүй, гэрээгээ биелүүлэхгүй байгаа нь маргааныг дагуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зохион байгуулах ажлын үр дүнг бууруулах нэг нөхцөл болсон байна.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5¹⁸-д заасны дагуу бодиттой тооцоо, судалгаагүй байна.
- Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралт “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын 6 дугаар зүйлийн 6.1¹⁹-д заасны дагуу бүх талуудын оролцоог хангаж ажиллаагүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөөр 314.6 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д заасны дагуу шаардагдах санхүүжилтийг тусгуулсан байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг аймгийн хэмжээнд цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүг залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр “Start up” арга хэмжээнд 1 бүлийг 10.0 сая төгрөг, Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн 2 төслийг сонгон шалгаруулж 100.0 сая төгрөгөөр дэмжсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан ч “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болох ажлын байрыг тусгаагүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс, орон нутгийн онцлогт нийцүүлсэн төслийг хэрэгжүүлсэн ч хяналт тавьж ажиллаагүй байна.
- Хууль дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй бөгөөд гүйцэтгэлийг хэмжих шалгуур тодорхой бус байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнг бодитой тайлагнаж үнэлээгүй байна
- Нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем бий болоогүй, ашиглаж байгаа программ хангамж шаардлага хангахгүй, мэдээллийн системийн бодитой бус бүртгэлээс болж арга хэмжээнүүдийн үр дүнг тооцох боломжгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцоогүй, салбар зөвлөлөөр дүгнүүлээгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр 2019 онд Швейцарын хөгжлийн агентлагаас залуучуудын

¹⁸ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэнэ

¹⁹ Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нийгмийн түнш, иргэдийн оролцоотойгоор хариуцан зохион байгуулна

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулсан, мөн Булган хангай МСҮТ, ХААМСҮТ-д ОУ-ын санхүүжилтээр 1358.4 сая төгрөгийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр сургалтын орчноо сайжруулсан.

- Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг жил бүр ХХҮЕГ, орон нутгийн удирдлага, салбар зөвлөлд тайлагнадаг боловч үнэлээгүй, дүгнэлт өгөөгүй байна.
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9²⁰-д зааны дагуу эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр төлөх үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9.6²¹, 29.9.13²²-д заасны дагуу холбогдох байгууллагад албан тоот хүргүүлдэг ч орлого дутуу төвлөрсөн байна.
- ХЭДС-ийн хөрөнгийг зарцуулахдаа хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, үр нөлөөнд нотлох баримт бүрдээгүй тул үнэлэх боломжгүй байна.

-oOo-

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг дарга, Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлд:

1. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж буй асуудал, түүнтэй холбоотой асууж тодруулсан зүйлс, санал, шүүмж, шийдвэрийг хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгаж хурлын тэмдэглэлийг хүчин төгөлдөр болгох,

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт:

1. Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, үйлчилгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллээр цахим нэгдсэн бүртгэл үүсгэх, шинэчлэлийг тухай бүр хийж хэвших,
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргах, орлого бүрдүүлэх боломжит тооцооллыг хийж хэвших,
3. Дотоод болон хөндлөнгийн байгууллагаар хийгдсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр илэрсэн алдаа, зөрчил, салбар зөвлөлөөс өгсөн үүрэг чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн ажил, гүйцэтгэл биелэлтийг гаргах, хэрэгжилтийг тухай бүр тооцоох,

-oOo-

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй төлбөрийг төрийн болон төрийн өмчит ААН, байгууллагын төсөвт тусгуулах асуудлыг Сангийн яаманд хүргүүлэх,
2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэл, нийлүүлэлтийн судалгааг тодорхой хугацааны давтамжтай хийх, шаардагдах төсвийг төсөв болон дунд хугацааны бодлогод тусгах саналыг ХНХЯ-д хүргүүлэх,
3. Зээлийн гэрээнд зээлдэгчийн хүлээх үүргийн тодорхой тусгах, шинэчлэх,
4. ХЭДС-гийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийг үнэлэх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох
5. Ашиглалтын шаардлага хангахгүй бүртгэл, мэдээллийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах зөвлөмжийг ХХҮЕГ-т хүргүүлэх,

²⁰ Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажил олгогчийн жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй

²¹ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийг байгууллага, иргэнд сурталчлах,

²² энэ хуулийн 22.1.7-д заасан төлбөрийг төвлөрүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

-oOo-